



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 164

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 33,900,000.00 (гучин гурван сая есөн зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 7,062,502.50 (долоон сая жаран хоёр мянга таван зуун хоёр төгрөг тавин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг Үндэсний урлагийн их театрт балансаас балансад шилжүүлсүгэй.

2."Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчийн хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярсайхан, Үндэсний урлагийн их театрын захирал Г.Цоггэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА


Д.НАРАНГЭРЭЛ



132001412

\Huraldaanii material\2021 on\2021.05.20 8-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2021 оны 05 дугаар сарын 20. өдрийн
..... дугаар тогтолын хавсралт



**Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй автомашинийг
Үндэсний урлагийн их театрт балансаас шилжүүлэх хөрөнгийн жагсаалт**

№	Автомашини нэр, Марк услын бүртгэл, арлын Дугаар	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжэ э	Нийт гүйп (км)	Балансын үнэ (төгрөг)	Хурумтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Суудлын автомашин, Соната-8, 88-21УБО, арлын дугаар 1 КМНЕ341DBGA179169	2016/2019	Ш	1	42259	33,900,000.00	7,062,502.50	26,837,497.50
							7,062,502.5 /долоон сая жаран хоёр мянга таван зүүн хоёр төгрөг тавин мөнгө/ Нийт дун мянган төгрөг/ мөнгө/	26,837,497.5 /хорин зургаан сая найман зуун гучин долоон мянга дөрвөн зүүн өрэн долоон төгрөг тавин мөнгө/